

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

Дуламсүрэнгийн Оюунбилэг

**ШИЛЖИН СУУРЬШИГЧ НАСАНД ХҮРЭГЧДИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ,
ХЭРЭГЦЭЭ**

/Е 720001 Нийгмийн эрүүл мэнд/

Нийгмийн эрүүл мэндийн магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл

Улаанбаатар хот

2008 он

Энэхүү ажлыг ЭМШУИС-ийн НЭМС (захирал Н.Сүмбэрзул, АУ-ны доктор дэд профессор), Эпидемиологи биостатистикийн тэнхим (тэнхмийн эрхлэгч О.Чимэдсүрэн, АУ-ны доктор)-д хийж гүйцэтгэв.

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

О. Чимэдсүрэн, Анагаах ухааны доктор

Эрдэм шинжилгээний ажлын зөвлөх:

Ө.Ганчимэг, Анагаах ухааны магистр

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

Б.Оргил, Анагаах ухааны доктор, профессор

Магистрын хамгаалалт 2008 оны 01 сарын 30 өдрийн 15.00 цагт ЭМШУИС-ийн 220 тоот өрөөнд болно.

Биоанагаах, НЭМ-ийн салбарын эрдэмтдийн зөвлөлийн нарийн бичгийн дарга:

.....О.Чимэдсүрэн, Анагаах ухааны доктор (PhD)

Улаанбаатар хот

2008

УДИРТГАЛ

Судалгааны ажлын үндэслэл

2000 онд хийсэн Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаагаар хөдөөнөөс шилжин ирэгсдийн 30 орчим хувь нь Улаанбаатар, Дархан-Уул, Орхон аймагт шилжин суурьшсан гэсэн үр дүн гарсан ба 2000 оны хүн амын тооллогын дүнгээс үзэхэд Улаанбаатар хотод байнга оршин суугчдын 32 хувь нь бусад аймаг, хотоос шилжин суурьшигсад байна. Мөн тооллогоор сүүлийн 4 жилийн дотор шилжилт хөдөлгөөнд оролцсон иргэдийн дөрөвний нэг орчим нь сүүлийн нэг жилд, харин сүүлийн 3 жилд шилжих хөдөлгөөнд оролцогсдын 42.6 хувь нь сүүлийн нэг жилд шилжигсэд байна.

1990 – 2000 оны хооронд Улаанбаатар хотод 95435 хүн шилжин ирсэн байхад Улаанбаатар хотын Иргэний бүртгэлийн байгууллагад 53935 хүн бүртгэгджээ(Үндэсний Статистикийн Газрын тайлан, 2001). Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас шилжүүлэггүй оршин сууж буй иргэд 47863 буюу нийт хүн амын 7 хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр суурин бус иргэдийн зардал тухайн дүүргийн төсөвт тусгагдаггүй учир эрүүл мэндийн болон бусад төрийн үйлчилгээний байгууллагын хэвийн үйл ажиллагаанд болон шилжин суурьшигчдад өөрсдөд нь бэрхшээл учирдаг байна.

Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын “Хүний эрх, эрх чөлөөний тухай 2003 оны илтгэл” – д “Иргэдийн эрх ноцтой зөрчигдөж байгаагийн нэг шалтгаан бол орон нутгаас нийслэл хотод болон төвийн бүсийн зарим аймгуудад шилжин суурьшигчидтай холбоотой нэмэгдэж буй хүндрэл гэж тэмдэглэсэн байна.

Иймээс шилжин суурьшигч иргэдэд болон төрийн үйлчилгээний байгууллагуудад тохиолдож буй хүндрэл бэрхшээлийг багасгах, иргэний бүртгэлийн тогтолцоонд өөрчлөлт хийж, шилжин суурьшигчдын иргэний бүртгэлд хамрагдалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа бөгөөд тэдний нийгмийн халамж үйлчилгээ хүртэх эрхийг хангах бодлого, шийдвэр боловсруулахад ашиглагдах нотолгоонд суурилсан мэдээ, мэдээлэл хомс байгаатай уялдан тус судалгааг явууллаа.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО

Сонгосон аймаг, хот дахь шилжин суурьшигч насанд хүрэгчдийн иргэний бүртгэл, эдийн засгийн байдал, эрүүл мэнд, нийгмийн зарим суурь тусламжийн хүртээмж, хэрэгцээг судлах

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛТ

1. Шилжин суурьшигчдийн иргэний бүртгэлийн хасалт, бүртгэлийн үеийн хүндрэлийг тодорхойлох
2. Шилжин суурьшигчдийн иргэний бүртгэлд хамрагдалтын түвшин, бүртгэлгүйн шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох
3. Шилжин суурьшсан насанд хүрэгчдийн ажил эрхлэлт, амьжиргааны эх үүсвэр, орлого, зарлага зэрэг эдийн засгийн байдлыг судлах
4. Шилжин суурьшигч насанд хүрэгчдийн эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдалтын одоогийн түвшинг үнэлэн, хэрэгцээг тодорхойлох, тэдний эдгээр үйлчилгээг хүртэхэд учирч буй бэрхшээлийг илрүүлэн шийдвэрлэх боломж, арга замыг судлах

СУДАЛГААНЫ АЖЛЫН ТААМАГЛАЛ

1. Иргэний бүртгэлд хамрагдалт сонгогдсон аймаг дүүрэгт ялгаатай.
2. Шилжин суурьшигчдын ядуурлын түвшин тухайн бүсийн нийт хүн амын ядуурлын түвшингээс өндөр.
3. Бүртгэлгүй иргэдийн эрүүл мэндийн тусламжинд хамрагдалт нийт шилжин суурьшигчдын эрүүл мэндийн тусламжид хамрагдалтаас бага.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ШИНЭЛЭГ ТАЛ

1. Шилжилт хөдөлгөөн хийж байгаа иргэдэд учирч байгаа бэрхшээлийг шатлал бүрээр гаргасан.
2. Шилжин суурьшигчдийн амьжиргааны түвшинг ядуурлын үзүүлэлтүүдтэй уялдуулан тооцсон
3. Шилжин суурьшигч насанд хүрэгчдэд үзүүлж буй эрүүл мэнд, нийгмийн зарим суурь тусламжийн одоогийн байдал, хэрэгцээг бүртгэлтэй болон бүртгэлгүй иргэдийн хувьд тодорхойлон цаашид боловсронгуй болгох санал зөвлөмж гаргасан

СУДАЛГААНЫ АЖЛЫН ПРАКТИК АЧ ХОЛБОГДОЛ

- Шилжилт хөдөлгөөн хийхэд гарч буй хүндрэл бэрхшээлийг тооцож иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг боловсронгуй болгох талаар бодлого боловсруулахад ашиглах боломжтой
- Шилжигч буюу насанд хүрэгчдийн эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж, хэрэгцээ, хамрагдалтыг үнэлснээр явуулж буй үйл ажиллагааны үр дүн, цаашдын стратегийг тодорхойлоход ач холбогдолтой.
- Шилжин суурьшсан насанд хүрэгчдийн нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэл, үйл ажиллагааны талаар хөтөлбөр, бодлого боловсруулахад ашиглагдах нотолгоог бүрдүүлэх

ХАМГААЛАХААР ДЭВШҮҮЛЖ БУЙ АСУУДЛУУД

1. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой шилжигч иргэдэд тохиолдож буй хүндрэл бэрхшээлийг гаргасан судалгааны дүн
2. Шилжин суурьшигчдын эдийн засгийн байдал, амьжиргааны түвшинг ядуурлын үзүүлэлтүүдтэй уялдуулан тооцсон судалгааны дүн
3. Шилжин суурьшигч насанд хүрэгчдэд үзүүлж буй эрүүл мэнд, нийгмийн зарим суурь тусламжийн хүртээмж, хэрэгцээний чиглэлийг гаргасан судалгааны үр дүн

СУДАЛГААНЫ АЖЛЫН ХЭЛЭЛЦҮҮЛСЭН БАЙДАЛ

1. Судалгааны ажлын ерөнхий удирдамж, арга зүйг ЭМШУИС-ийн НЭМС-ийн Эпидемиологи Биостатистикийн тэнхимээр хэлэлцүүлэв. (Протокол № 23)
2. Судалгааны ажлын ёс зүйн дүгнэлтийг ЭМШУИС-ийн Биоанагаахын ёс зүйн зөвлөлийн 2007 оны 11 сарын 20-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан (хурлын тэмдэглэл №48/1)
3. Судалгааны ажлын үр дүнг ЭМШУИС-ийн НЭМС-ийн Эпидемиологи Биостатистикийн тэнхимээр хэлэлцүүлэв. (Протокол №31)
4. “Хот суурин газарт шилжин суурьшигсдийн ахуйн нөхцөл” ЭМШУИС-ийн “Эрдмийн чуулган 49” Нийгмийн эрүүл мэнд боловсрол судлалын салбар хуралдаан 2007 оны 04 сар
5. “Шилжих хөдөлгөөн, бүртгэлийн асуудалд” ЭМШУИС-ийн “Эрдмийн чуулган 49” Нийгмийн эрүүл мэнд боловсрол судлалын салбар хуралдаан 2007 оны 04 сар

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Атармаа. Д,Цолмон Ч, Нямхүү Д. Анагаах ухааны хүн ам зүй.Улаанбаатар. 2002 х 88, 90
2. Гансүх П, Монгол улсын хүн ам зүйн менежмент. Улаанбаатар. 2000. х 23
3. Гейтс П."Шилжих хөдөлгөөн ба Хөдөөгийн гэр бүл: Туламжийн эх үүсвэр ба шилжилтийн урсгал", Хүн ам, нийгмийн судалгааны институт, Махидол их сургууль, 1977. х 51
4. Гейтс П. "Шилжих хөдөлгөөний өөрчлөлт: АНУ-ын бүс нутагт", АНУ-ын бүсийн хүн амын сэтгүүл, 1999. х 45
5. ДЭМБ, ЭМЯ, ЭТУГ, 2003. Дотоод шилжих хөдөлгөөн ба түүний нийгмийн эрүүл мэндийн үр дагавар, 2003. Улаанбаатар х 24-28
6. Монгол Улсын Засгийн Газар"Иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх талаар авах арга хэмжээний тухай тогтоол" дугаар 47, Улаанбаатар, 1996 х 3
7. Монгол Улсын Засгийн Газар, "Монгол улсын статистикийн эмхтгэл", Үндэсний Статистикийн газар, Улаанбаатар, 1999 х 14
8. Монгол Улсын Засгийн Газар, "Амьжиргааны түвшинг тооцооны аргаар судлах нь" Үндэсний статистикийн газар, Улаанбаатар, 2000 х 18
9. Монгол Улсын Засгийн Газар, НҮБ. Монголын хүний хөгжлийн илтгэл, хот хөдөөгийн ялгаатай байдал. 2003. Улаабаатар, х 45
10. Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хууль
11. Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэд шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам
12. Монгол Улс дахь Хүний Эрхийн Үндэсний комисс, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл, 2004. Улаанбаатар, х 34
13. Монгол Улс дахь Хүний Эрхийн Үндэсний комисс, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл, 2005. Улаанбаатар, х 21
14. Монгол Улс дахь Хүний Эрхийн Үндэсний комисс, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл, 2006. Улаанбаатар, 18
15. Монгол Улсын Засгийн газар, Хүн амын сургалт судалгааны төв, 2004. Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн судалгааны тайлан. Улаанбаатар, Монгол

16. Монголын хүн ам ба хөгжил нийгэмлэг, МУИС, ХАССТ, НҮБ, ХАС. Монголын хүн амын сэтгүүл 14. Улаабаатар 2006 х 35, 45, 48
17. МУИС, ЭЗС, ХАССТ, Хүн ам зүйн үндсэн асуудлууд. Улаанбаатар, 2006.х - 77-90
18. МУИС, ЭЗС, Хүн амын бодлого. Улаанбаатар, 2005. х 43
19. Нойберт Р, “Монголын хүн амын байршилт, хотжилт”, Зүүн-Баруун төв, ОР, № 122, 1994 х 56
20. НҮБ, “Хүн ам ба хөгжил” олон улсын бага хурлаас гаргасан баримт бичиг, Кайро, Египет, 1994. х 65, 68
21. НҮБ-ийн ХАС, Дэлхийн хүн амын байдал 2007, “Хотжилтын нөөц боломжийг ашиглах нь” х 34
22. НҮБ, ХАС, “Дэлхийн хүн амын байдал 2006” х 6-7
23. НҮБ-ын ХАС, “Монгол улсын хүн амын төрөлт, нас баралт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа”, Улаанбаатар, 2002
24. Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам, Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн хууль тогтоомжийн эмхтгэл. Улаанбаатар, 2006. х 8
25. Нээлттэй нийгэм форум, 2004. Монгол дахь ядуурлын асуудалтай холбогдох ном зүй. Улаанбаатар, х 36-41
26. Робинзон Б, Солонго А, “Шилжилтийн нөхцөл дэх жендерийн байдал” Монголын эдийн засаг, шилжилтийн үеийн гарын авлага, бүлэг 12, Улаанбаатар, Манчестр, 1999 х 78
27. Улсын Их Хурлын Тамгын газар, 2003. Төрийн мэдээлэл. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл, 2003. Улаанбаатар, х 15
28. УИХ-ын Нийгмийн Бодлогын Байнгын Хороо, НХХЯ, Хүн амын хөгжлийн асуудлаарх Азийн парламентчдын форум, НҮБХАС, Хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаарх үндэсний дээд хэмжээний уулзалт, 2005. Улаанбаатар, 2005. х 9-10, 12-18
29. ҮСГ, 2004. Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан, 2002-2003. Үндэсний статистикийн газар, Улаанбаатар, х 16
30. ҮСГ, 2002. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого: Монгол улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хотжилт. Үндэсний статистикийн газар, Улаанбаатар, х32, 41
31. ҮСГ, НҮБХАС, Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чанарын судалгааны тайлан. Улаанбаатар, 2006. х 18

32. ҮСГ, Дэлхийн банк, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр “Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгааны үндсэн тайлан 2002-2003”, Улаанбаатар, 2004 х 98
33. ҮСГ, НҮБ-ын ХАС, “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа”, Улаанбаатар, 1999 х 59
34. Эмэгтэйчүүдийн Мэдээлэл Судалгааны Төв, “Шилжилтийн үеийн Монголын Эмэгтэйчүүдийн эдийн засгийн статус”, судалгааны илтгэл, Улаанбаатар, 1997 х 51
35. Эрүүл Мэндийн Яам, “Шилжих хөдөлгөөнд хамрагсдын эрүүл мэнд”, Улаанбаатар, 2003 х 66
36. Эрүүл Мэндийн Улсын Хяналтын Алба, 2002. Эрүүл мэндийн болон эмийн холбогдолтой хууль эрхийн актын эмхэтгэл. Улаанбаатар, х 35
37. birding.about.com/od/migration/seasonal_Migration_of_Birds.htm
38. en.wikipedia.org/Migration
39. en.wikipedia.org/Human_Migration
40. Government Mongolia, UNDP Mongolia, 2004. Urban poverty and in-migration survey report. Ulaanbaatar, Mongolia
41. International Migration Report, United Nations, New York 2002 pp 61
42. International Migration: An Emerging Opportunity for the Socio-economic Development of the ESCAP Region, United Nations, New York, 2002 pp 75
43. Levels and Trends of international Migration to Selected Countries in Asia, United Nations, New York, 2003 pp 58
44. Ministry of Social Welfare and Labour, Population Teaching and Research Center, United Nations Population Fund, 2001. A micro study of internal migration in Mongolia, Ulaanbaatar, Mongolia
45. Migration and Poverty. Asia-Pacific Population Journal, Vol 17, No 4. 2002 pp 45
46. migration.ucdavis.edu
47. NSO, UNFRA, 2006 Report of a qualitative study of internal migration in Mongolia, Ulaanbaatar, Mongolia
48. Poverty and Mortalty in the Context of Economic Growth and Urbanization. Asia-Pacific Population Journal, Vol 17, No 4. 2002 pp 32
49. Social aspects of international Labour Migration in the ESCAP Region, UN ESCAP, 2001pp 21
50. www.operationmigration.org

51. www.hummingbirds.net/migration.htm/
52. www.hpwrc.usgs.gov/vsource/birds/migratio
53. www.enature.com/birding/migration_home.asp
54. www.migrationinformation.org
55. www.britannica.com/eb/article-91104241migration